



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/011/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453317, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Авирмэд Утас: 70453317, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Нэмэлт төсөв

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ЗАВХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Т.ТАМИР ТАНАА

2026.02.23 № УВА-2026/011/НА-СТА-ТН13
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Завхан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050262

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>70,416,043.50</u>	<u>42,437,650.50</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	70,416,043.50	42,437,650.50
354	Хангамжийн материал	62,471,499.50	38,490,439.50
35410	Бичиг хэргийн материал	2,000,800.00	2,813,250.00
35420	Аж ахуйн материал	32,370,939.00	25,573,089.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,370,000.00	1,130,000.00
35440	Түлш, шатах тослох материал	9,000,040.50	40.50
35470	Бусад хангамжийн материал	15,729,720.00	8,974,060.00
35600	Мал амьтад	7,944,544.00	3,947,211.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,140,906,556.43</u>	<u>1,568,965,966.38</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,140,906,556.43	1,568,965,966.38
392	Биет хөрөнгө	1,119,055,376.43	1,544,114,786.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	748,852,476.54	1,137,351,172.54
39202	Хуримтлагдсан элэгдэл	-251,206,353.94	-298,427,134.67
39203	Авто-тээврийн хэрэгсэл	122,383,700.00	149,560,973.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-40,333,950.08	-58,668,200.12
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	216,502,855.62	198,028,945.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	-135,727,359.49	-134,362,093.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,023,550.00	47,553,121.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-40,598,966.89	-41,421,205.08
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,063,071,318.00	1,159,364,887.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-609,911,893.33	-614,865,679.77
393	Биет бус хөрөнгө	21,851,180.00	24,851,180.00
39301	Програм хангамж	1,995,000.00	4,995,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,995,000.00	-1,995,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	21,851,180.00	21,851,180.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,211,322,599.93</u>	<u>1,611,403,616.88</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>288,000.00</u>	<u>39,089,186.97</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	288,000.00	39,089,186.97
413	Өглөг	288,000.00	39,089,186.97
4136	Бусад өглөг	288,000.00	39,089,186.97
41361	Байгууллагад төлөх өглөг	288,000.00	39,089,186.97
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,211,034,599.93</u>	<u>1,572,314,429.91</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,211,034,599.93	1,572,314,429.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	470,247,326.99	470,247,326.99
51101	Өмч: - төрийн	470,247,326.99	470,247,326.99
512	Хуримтлагдсан үр дүн	486,090,998.29	847,370,828.27
51210	Өмнөх үеийн үр дүн	486,090,998.29	486,090,998.29
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	361,279,829.98
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	254,696,274.65	254,696,274.65

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,211,322,599.93</u>	<u>1,611,403,616.88</u>
---	--	-------------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,140,832,549.00	1,807,227,032.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	237,735,540.00	588,990,735.93
120	Нийтлэг татварын бус орлого	237,735,540.00	588,990,735.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	237,735,540.00	588,990,735.93
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,502,511.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,191,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	230,042,029.00	588,990,735.93
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	903,097,009.00	1,218,236,297.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	13,145,009.00	00.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	13,145,009.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	280,389,597.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	267,295,432.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	13,094,165.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	889,952,000.00	937,846,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	889,952,000.00	937,846,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,015,557,954.09	1,444,307,202.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,015,557,954.09	1,444,307,202.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	950,961,835.81	1,430,896,822.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	598,893,565.42	732,803,925.97
210101	Үндсэн цалин	400,034,208.34	435,068,865.77
210102	Нэмэгдэл	198,859,357.08	295,264,764.02
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	2,382,796.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,447,523.12	87,637,267.00
210201	Тэтгэврийн даатгал	50,590,956.16	61,413,267.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,951,877.21	6,556,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,371,764.14	3,278,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,975,938.60	3,278,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,556,987.01	13,111,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,692,136.08	76,630,150.03
210301	Гэрэл, цахилгаан	6,007,336.08	13,362,550.03
210302	Түлш, халаалт	66,684,800.00	63,267,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,051,987.50	38,874,560.00
210401	Бичиг хэрэг	4,527,980.00	1,486,650.00
210402	Тээвэр, шатахуун	18,970,257.50	16,034,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,650,000.00	1,980,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	392,200.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,511,550.00	19,373,410.00
2105	Нормативт зардал	00.00	3,530,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	3,530,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,017,955.00	14,882,333.00
210604	Урсгал засвар	3,017,955.00	14,882,333.00
2107	Томилолт, зочны зардал	8,833,000.00	19,750,800.00
210702	Дотоод албан томилолт	8,833,000.00	19,750,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,010,602.00	684,211.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	806,025.00	85,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	643,052.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	106,525.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	219,616.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	00.00
210807	Газрын төлбөр	00.00	91,495.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	164,015,066.69	456,103,575.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,586,220.10	288,899,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,131,800.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	122,297,046.59	167,291,325.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,596,118.28	13,410,379.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,968,056.00	7,380,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,520,000.00	7,260,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,182,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,266,056.00	120,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	27,628,062.28	6,030,379.97
213404	Хөрөнгийн	00.00	2,672,999.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>125,274,594.91</u>	<u>362,919,829.97</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,639,999.99
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,639,999.99
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,639,999.99
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>125,274,594.91</u>	<u>361,279,829.98</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>910,790,520.00</u>	<u>1,218,236,297.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,693,511.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,693,511.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,693,511.00	00.00

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,502,511.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,191,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	903,097,009.00	1,218,236,297.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	13,145,009.00	00.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	13,145,009.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	280,389,597.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	267,295,432.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	13,094,165.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	889,952,000.00	937,846,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	889,952,000.00	937,846,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	910,790,520.00	1,024,140,865.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	910,790,520.00	1,024,140,865.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	845,849,401.72	1,010,170,485.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	600,854,494.06	701,711,100.00
210101	Үндсэн цалин	392,254,619.56	404,063,539.80
210102	Нэмэгдэл	208,493,370.41	295,264,764.02
210105	Гэрээт ажлын хөлс	106,504.09	2,382,796.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,486,594.48	87,637,267.00
210201	Тэтгэврийн даатгал	49,065,381.16	61,413,267.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,824,311.80	6,556,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,058,490.80	3,278,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,006,814.41	3,278,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,531,596.31	13,111,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,857,136.08	76,037,448.61
210301	Гэрэл, цахилгаан	6,172,336.08	12,769,848.61
210302	Түлш, халаалт	66,684,800.00	63,267,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,614,600.00	17,702,569.42
210401	Бичиг хэрэг	3,293,180.00	2,379,651.42
210402	Тээвэр, шатахуун	23,178,620.00	11,765,418.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,579,000.00	1,650,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,985,300.00	1,732,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	578,500.00	175,000.00
2105	Нормативт зардал	1,867,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,867,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,630,455.00	7,975,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,200,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,430,455.00	7,975,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,771,500.00	8,085,200.00
210702	Дотоод албан томилолт	7,771,500.00	8,085,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,722,602.00	3,322,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	806,025.00	245,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	355,052.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	106,525.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,045,020.10	107,699,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,055,720.10	95,700,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,989,300.00	11,999,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,941,118.28	13,970,379.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,313,056.00	7,940,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,702,000.00	7,260,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,611,056.00	680,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	27,628,062.28	6,030,379.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,672,999.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	194,095,432.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	194,095,432.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	194,095,432.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	194,095,432.00
223001	Бусад хөрөнгө	00.00	194,095,432.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	194,095,432.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	470,247,326.99	254,696,274.65	255,108,359.42	980,051,961.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	470,247,326.99	254,696,274.65	255,108,359.42	980,051,961.06
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	107,320,710.68	107,320,710.68

2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470,247,326.99	254,696,274.65	486,090,998.29	1,211,034,599.93
2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	470,247,326.99	254,696,274.65	486,090,998.29	1,211,034,599.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	470,247,326.99	254,696,274.65	486,090,998.29	1,211,034,599.93
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	361,279,829.98	361,279,829.98
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470,247,326.99	254,696,274.65	847,370,828.27	1,572,314,429.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	961,719,200.00	935,173,700.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	961,719,200.00	935,173,700.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	947,459,200.00	927,233,700.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	701,196,600.00	701,196,600.00
210101	Үндсэн цалин	667,301,900.00	403,549,039.80
210102	Нэмэгдэл	00.00	295,264,764.02
210105	Гэрээт ажлын хөлс	33,894,700.00	2,382,796.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,578,100.00	87,578,100.00
210201	Тэтгэврийн даатгал	61,354,100.00	61,354,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,556,100.00	6,556,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,278,000.00	3,278,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,278,000.00	3,278,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,111,900.00	13,111,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,629,700.00	76,037,448.61
210301	Гэрэл, цахилгаан	12,708,500.00	12,769,848.61
210302	Түлш, халаалт	63,921,200.00	63,267,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,064,800.00	16,585,651.42
210401	Бичиг хэрэг	3,318,400.00	2,379,651.42
210402	Тээвэр, шатахуун	13,542,800.00	10,648,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,998,200.00	1,650,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,775,000.00	1,732,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	430,400.00	175,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,213,600.00	2,613,600.00
210604	Урсгал засвар	2,613,600.00	2,613,600.00
2107	Томилолт, зочны зардал	4,586,100.00	4,585,200.00
210702	Дотоод албан томилолт	4,586,100.00	4,585,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,765,300.00	3,322,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	455,300.00	245,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,400,000.00	3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41625000.00	35315100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,625,000.00	25,315,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,000,000.00	10,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14260000.00	7940000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,260,000.00	7,940,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,260,000.00	7,260,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,000,000.00	680,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	961,719,200.00	935,173,700.03
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	961,719,200.00	935,173,700.03
132001	Орон нутгийн төсвөөс	961,719,200.00	935,173,700.03
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00
620001	Удирдах ажилтан	07.00	07.00
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00
620004	Гэрээт ажилтан	05.00	05.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	82,936,785.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	82,936,785.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,936,785.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	514,500.00
210101	Үндсэн цалин	514,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,167.00
210201	Тэтгэврийн даатгал	59,167.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,116,918.00
210402	Тээвэр, шатахуун	1,116,918.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,361,400.00
210604	Урсгал засвар	5,361,400.00
2107	Томилолт, зочны зардал	3,500,000.00
210702	Дотоод албан томилолт	3,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72384800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,385,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,999,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	194,095,432.00
2200	Дотоод эх үүсвэрээр	194,095,432.00

223001	Бусад хөрөнгө	194,095,432.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	277,032,217.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	277,032,217.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	263,938,052.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,094,165.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан сумын Засаг даргын тамгын газар нь “Үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн зөв бодлого, зөв үйлдэл, зөв манлайллыг түүчээлэгч” төрийн байгууллага болно” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Завхан сумын Засаг даргын тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр, Нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10-р сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлс доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 4715 төгрөг буюу сард 792000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан сумын Засаг даргын тамгын газрын тайлант оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 400,080.1 мянган төгрөгөөр буюу 33 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	70,416.0	42,437.7	-27,978.3
Үндсэн хөрөнгө	1,140,906.6	1,568,965.9	428,059.3
Нийт хөрөнгө	1,211,322.6	1,611,403.6	400,081.0
Өр төлбөр	288.0	39,089.2	38,801.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,211,034.6	1,572,314.4	361,279.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,211,322.6	1,611,403.6	400,081.0

Бараа материалын дансны үлдэгдэл 42,437.6 мянган төгрөг болж 27,979.0 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал болон бусад хангамжийн материалын үлдэгдэл буурснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 1,568,965.9 мянган төгрөг болж 428,059.4 мянган төгрөгөөр өсөхөд хандиваар хөрөнгө нэмэгдэж ирсэн нөлөөлсөн байна.

Өглөг дансны үлдэгдэл 39,089.2 мянган төгрөг болж 38,801.2 мянган төгрөгөөр өсөхөд хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг үүссэн нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,572,314.4 мянган төгрөг болж 361,279.9 мянган төгрөгөөр өссөн тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,275,340.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа үйлчилгээний зардлыг 35,276.8 мянга, эд хогшил худалдан авах зардал 13,000.0 мянган төгрөгөөр бууруулж мал тооллого, орон нутгийн нөөц, тэтгэмж урамшуулал зэрэг зардал төлөвлөсөн хэмжээнээс 50 хувиар бууруулж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 3 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 961,719.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 937,846.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 935,173.7 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь 23,872.5 мянган төгрөгийн санхүүжилт дутуу ирж, 2,673.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	611,233.4	599,970.1	11,262.6	98.1%
2	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 80106-Баг хорооны зардал	171,025.4	169,572.7	1,452.6	99.1%
3	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	78,330.2	78,330.2	0	100%
4	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 80112-Нийтлэг үйлчилгээ	52,312.4	52,312.4	0	100%
5	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 80205-Мэдээлэл сурталчилгааны зардал	157.8	0.0	157.8	0
6	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	14,260.0	7,940.0	6,320.0	55.6%
7	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	12,000.0	9,944.6	2,055.4	82.8%
8	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 81507-мал тооллого	650.0	0	650.0	0%
9	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 82212-хур хог хаягдал орчны бохирдол	5,775.0	1,732.5	4,042.5	30%
10	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 82801-Улсын баяр наадам	5,000.0	4,750.0	250.0	95%
11	71413-Байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх 81701-байгаль орчин нөхөн сэргээх	10,375.0	10,020.5	354.5	96.5%
12	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 81549-Ахмадын сан	600.0	600.0	0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Завхан сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 263,938.1 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 13,094.1 мянган төгрөг, нийт 280,389.5 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж 277,032.1 мянган төгрөгийг зарцуулж, 3,357.3 мянган төгрөгийг зарцуулах эрх хязгаарласнаас шалтгаалан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Хүснэгт 3. Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжтай холбоотой гарсан зардал	3,000.0	Си Ти Эйс санхүүгийн программ
2	Унаа хоолны зардлын гүйцэтгэл	0.0	Байхгүй
3	Сургалт семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардал	0.0	Байхгүй
4	Гадаад томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардал	0.0	Байхгүй
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал	0.0	Байхгүй
6	Байгууллагын орон тоо	0.0	Байхгүй
7	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл	0.0	Байхгүй

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Завхан сумын Засаг даргын тамгын газарт тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Завхан сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд тендер зарласан үйл ажиллагаа байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Завхан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Завхан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,017,170.6 мянган төгрөгийн 1 хувиар буюу 10,171.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 8,137.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,444,307.2 мянган төгрөгийн 1 хувиар буюу 14,443.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 11,554.5 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Завхан сумын Засаг даргын тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Завхан сумын Засаг даргын 2025 оны А/13, А/19 дүгээр захирамжаар бэлэг дурсгалын зүйлд 1,340.0 мянган төгрөг зарцуулсан зөрчилд албан шаардлага өглөө.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Завхан сумын Засаг даргын тамгын газар нь Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 733,286.1 мянган төгрөгийн орлогын 10 гүйлгээ, Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 255,317.6 мянган төгрөгийн зарлагын 5 гүйлгээ, 247,957.0 мянган төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 37 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй зөрчилд зөвлөмж өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.6.1-т “Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 35.6-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол банктай хамтран баталсан журмын дагуу бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картын данстай байж болно”, 3.6.2-т “Төсвийн байгууллага нь энэ журмын 3.6.1-д заасан картын дансанд зөвхөн төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвшөөрөгдсөн төлбөрийг шилжүүлэн авч, зориулалтын дагуу зарцуулна” гэж заасан байхад Сангийн яамнаас чиглэл өгч төсвийн байгууллагуудын картыг дансыг хаалгаснаас шалтгаалан байгууллагын нярвын дансаар бэлэн мөнгө зарцуулж байгаад зөвлөмж өглөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн баталсан бүтэц орон тоонд байхгүй багийн сахиул-4, сантехникч-1, олон нийтийн байцаагч-1, нийт 6 гэрээт ажилтан ажиллуулсан асуудлыг дараачийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,274,535.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,340.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,273,195.4 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

5.1 Албан шаардлага

Завхан сумын Засаг даргын 2025 оны А/13, А/19 дүгээр захирамжаар бэлэг дурсгалын зүйлд 1,340.0 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.6 дахь заалтад “Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж, төсвөөс хуулиар зөвшөөрөгдөөгүй зардал гаргахгүй байх албан шаардлага өглөө.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангиллыг зөрчиж 653.2 мянган төгрөгийн 2 гүйлгээ хийсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллах.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 733,286.1 мянган төгрөгийн орлогын 10 гүйлгээ, Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 255,317.6 мянган төгрөгийн зарлагын 5 гүйлгээ, 247,957.0 мянган төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 37 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах.

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Завхан сумын Засаг даргын тамгын газрын нярвын дансаар дамжуулан 35,981.5 мянган төгрөгийг бэлнээр гаргаж зарцуулсан байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид байгууллагын нярвын хувийн дансаар бэлэн мөнгө гарган зарцуулахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
							Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хууль, тогтоомж зөрчсөн	2	1,993.2			1	1,340.0	1	653.2				
Дүн	2	1,993.2			1	1,340.0	1	653.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээлэл байршуулаагүй	1	1,236,560.7					1	1,236,560.7
Дүн	1	1,236,560.7					1	1,236,560.7
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хууль, тогтоомж зөрчсөн	1	35,981.5					1	35,981.5
Дүн	1	35,981.5					1	35,981.5
Нийт дүн	2	1,272,542.2					2	1,272,542.2

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Б.АВИРМЭД/

2026 оны 02 дугаар сарын 15-ны өдөр